

БАТЛАВ.  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

БАЯРВАДТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн  
төслийн үзэл баримтлал

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д зааснаар Улсын Их Хурал "терийн санхүү, зээл, албан татвар, менгений бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцуулэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэдэг.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад "Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах"-аар, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт "Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлын хаврын эзлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй уялдуулан хэлэлцэнэ" гэж тус тус заасан хэдий ч энэ онд Улсын Их Хурлын эзлжит сонгуулийн жил тохиосон учраас Улсын Их Хурлын 2024 оны хаврын эзлжит чуулганыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр завсарлуулж, дээр дурдсан хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж амжаагүй байна.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Улсын Их Хурлаас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2024-2028 онд бүрэн эрхээ хэрэгжүүлэх Улсын Их Хурал үйл ажиллагаандaa хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт "Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно." гэж заасны дагуу 2020-2024 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагчид нь буцаасан байна.

Улсын Их Хурлын эзлжит сонгуулийн жил хэлэлцэн батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудал буюу нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг баталж байсан хугацааны талаар лавлагaa гаргаж үзвэл 2015 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газраас 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр хэлэлцэн баталж байсан байна. Мен 2019 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газраас 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурал 2020 оны 08 дугаар сарын 27-ний өдөр хэлэлцэн баталжээ.

Иймээс хуульд хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь тусгайлан заасан зарим асуудлыг Улсын Их Хурлын эзлжит сонгууль явагдах жилд өмнөх Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж

амжаагүй тохиолдолд шинээр бүрдэж, бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага үүсэж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Улсын Их Хурлын бие даасан байдлыг тусгахдаа мөн зүйлийн 4.1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хэн ч халдаж үл болно. Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиас бусад хуулиар зохицуулахыг хориглоно." гэж, 4.2 дахь хэсэгт "Улсын Их Хурал хуралдааны дэгээ өөрөө тогтооно." гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтад "Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах ба бусад хуулийн төслийг өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэх, батлахдаа дагалдах хэлбэрээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно." гэж заасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлэхээр төслийг боловсруулна.

#### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 2 зүйлтэй байхаар боловсруулна.

1 дүгээр зүйлээр хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудлыг Улсын Их Хурлын эзлжит сонгуулийн жилийн хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн Улсын Их Хурал тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох зохицуулалтыг тусгана.

2 дугаар зүйлээр хуулийн төслийн дагаж мөрдөх хугацааг тусгана.

#### **Гурав.Хуулийн тесэл батлагдсаны дараа үүсэж болох зийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн тесэл батлагдсанаар Улсын Их Хурлын сонгуулийн жилээс хамааран бүрэн эрх нь дуусгавар болсон Улсын Их Хурлын хэлэлцэн шийдвэрлээгүй хуульд батлах хугацааг нь тусгайлан заасан хууль тогтоомжийн төслийг дараагийн шинээр бүрэн эрх нь хэрэгжих Улсын Их Хурал хэлэлцэн батлах боломж бүрдэнэ.

#### **Дөрөв.Хуулийн тесэл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн тесэл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцэж байгаа бөгөөд уг хуулийн теселтэй хамт боловсруулах хууль тогтоомжийн тесэл байхгүй болно.